




“ХҮННУ СТИЙЛ” ХХК
ЗАХИАЛАГЧ



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК
ГҮЙЦЭТГЭГЧ

2024

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



СЭЛЭНГЭ АЙМАГ, ЕРӨӨ СУМ

УЛААНБААТАР ХОТ
2024 он



АГУУЛГА

ОРШИЛ

Нэг. Төслийн товч танилцуулга

Хоёр. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

- 2.1. Төслийн нөлөөллийн цар хүрээ
- 2.2. Сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
- 2.3. Сөрөг нөлөөллийн үнэлгээ
- 2.4. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- 2.5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Гурав. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- 3.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт
- 3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 3.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- 3.4. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
- 3.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
- 3.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө
- 3.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- 3.8. Удирдлага, зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө
- 3.9. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- 3.10. БОМТ-г олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хавсралт



ОРШИЛ

Төсөл хэрэгжүүлэгч “ХҮННҮ СТИЙЛ” ХХК-ийн MV-017017 тусгай зөвшөөрөл бүхий Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Хустайн төмрийн хүдрийн орд ашиглах төсөл”-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан Уулын Оргил” ХХК боловсруулав.

Энэхүү БОМТ-нд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө(29), хог хаягдлын менежментийн төлөвлөгөө(8), осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө(9), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө(1), нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө(2), БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө(11), БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь(4)-т төлөвлөгөө болон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр(6) зэрэг нийт 70 ажилд 28.7сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн ба төслийн онцлог, байршлаас шалтгаалан түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хийгдэхгүй болно. Мөн энэ онд нөхөн сэргээлтийн арга хэмжээ хийгдэхгүй.

Хууль, журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг 90-ээс дээш хувьтайгаар орон нутгаар үнэлүүлсэний үндсэн дээр дараа жилийн БОМТ-г байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан ажиллахыг анхаарах нь зүйтэй.


Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XI дүгээр сарын 1-ний дотор тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг XII дугаар сарын 31-ний дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр:	"Хустайн төмрийн хүдрийн орд ашиглах төсөл"			
Ордын нэр:	Хустайн төмрийн хүдрийн орд			
Байршил:	Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Буургачин баг			
Төсөл хэрэгжүүлэгч:	"ХҮННҮ СТИЙЛ" ХХК	Улсын бүртгэлийн дугаар:	9011237003	РД: 5378834
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 21А-24 тоот, 99748084			
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-017017	Талбайн хэмжээ:	84.7га	
Ашигт малтмалын төрөл:	Төмөр	Ашиглах арга, хугацаа:	Ил уурхай - 10 жил	
Батлагдсан нөөц:	В зэргээр 10,517.2 мян.тн хүдрийн, 52.53%-н төмрийн дундаж агуулгатай 5,524.7 мян.тн төмрийн нөөц, С зэргээр 10,039.3 мян.тн хүдрийн 49.45%-н төмрийн дундаж агуулгатай 4,964.4 мян.тн төмрийн нөөц, В+С зэргээр 20,556.6 мян.тн хүдрийн 50.99%-н төмрийн агуулгатай 10,489.1 мян.тн төмрийн нөөц			
Талбайн нөөц:	Геологийн: В+С=19,042.6 мян.тн хүдэр, 9,731.3 мян.тн төмөр Үйлдвэрлэлийн: В+С=10,965.3 мян.тн хүдэр, 5,628.7 мян.тн төмөр			
Ашиглалтын технологи:	Тээвэртэй ашиглалтын систем			
Хүчин чадал:	Ил уурхай: 10 жил • Хүдэр олборлолт - 10,965.3 мян.тн • Хөрс хуулалт - 40,599.5 мян.м ³ Баяжуулах үйлдвэр • Хүдэр боловсруулалт -10,965.3 мян.тн • Төмрийн баяжмал гаргалт - 7,401.7 мян.тн			
Хүдэр баяжуулах технологи:	Хуурай соронзон баяжуулалт			
Ажиллах хүчин:	Уурхай: 156 хүн, Үйлдвэр: 17 хүн			
Ажиллах хоног:	Ил уурхай 328 хоног, Баяжуулах үйлдвэр 224 хоног			
Цахилгаан хангамж:	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Хустайн төмрийн хүдрийн уурхайн нутаг дэвсгэрт 110/6кВт-н дэд станц байгуулж, дэд станцаас 6кВт-н агаарын шугам татаж уулын хэсэг, засварын хэсгүүдэд тус бүр 6/0.4кВт-н трансформатор суурилуулан тэжээхээр төлөвлөсөн.			
Усан хангамж:	Баяжуулах технологид хуурай соронзон аргыг хэрэглэх учир ус ашиглахгүй. Уурхайн үнд ахуйн хэрэглээний усыг уурхайгаас 5км кайд орших гар худгаас, зам талбайн усалгааны усыг Ерөө голоос зөөврөөр авч хэрэглэнэ.			
Зам тээвэр:	Орон нутагтай ердийн хээрийн шороон замаар холбогдоно. Үйлдвэрийн болон уурхайн дотоод замууд байнгын усалгаа, арчилгаатай уурхайн сайжруулсан шороон зам байна.			
Байршил:	Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Буургачин багт Хустайн ар хэсэгт оршдог. Улаанбаатар хотоос хойд зүгт 330км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 16км, Дархан хотоос хойд зүгт 110км зайтай.			



Зураг 1. Төслийн байршил

Газар ашиглалт: Ордын үйл ажиллагаа эхлээгүй тул нийт эзэмшил газар сул талбайгаараа байгалийн төрхөөрөө байна.



Зураг 2. Газар ашиглалт

ХОЁР. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


2.1. Төслийн нөлөөллийн цар хүрээ

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийн орон зайн давхцалуудыг тодорхойлон хам сөрөг нөлөөллүүдийг үнэлж тогтоон тэдгээрийн буурах зай, эрчимшлийг тодорхойлов.

Хүснэгт 1. Нөлөөлөл буурах функц тодорхойлоход ашигласан утга

Үйл ажиллагааны төрөл	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн эх үүсвэрийн хэмжээ, га	Нөлөөллийн код	Нөлөөлөл буурах функц	Нөлөөлөл буурах зай, м	Нөлөөллийн эрчим
Ил уурхай	Талбай	38.4	10	Алгуур	1000	300
Үйлдвэрлэлийн талбай	Талбай	15.0	7	Алгуур	300	300
Хөрсний овоолго	Талбай	60.0	12	Алгуур	300	300
Хаягдлын овоолго	Талбай	5.2	18	Дунд	100	300
Тосгон	Талбай	9.6	4	Алгуур	1000	300
Засвар үйлчилгээний төв	Талбай	4.8	18	Дунд	100	300
Зам	Зурвас	9.4	7	Дунд	100	100

Тайлбар: Нөлөөллийн эрчим (Бага-100, Дунд-200, Их-300)



Зураг 3. Сөрөг нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ ба хүрээ, түүний эрчим

Хүснэгт 2. Нөлөөлөлд өртөх газар буюу талбайн хэмжээ

Нөлөөллийн эрчим	Талбай, га
Их	322.58
Дунд	90.33
Бага	366.74
Нөлөөлөлд өртөх нийт талбай: 779.65	



2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зөвлөмж

Арга хэмжээний чиглэл	Зөвлөмж
Агаарын чанарыг сайжруулах чиглэлээр	Хөрсний овоолгын нөхөн сэргээлтийн ажил эхлэх хүртэл овоолгоос үүсэх тоосжилтыг бууруулахын тулд овоолгын ашиглахгүй байгаа хэсгийн гадаргууг сайтар нягтруулж, том ширхэгтэй чулуу, хайргаар хучих хэрэгтэй.
	Салхи ихтэй буюу тоосжилт ихээр үүсэх нөхцөл бүрдсэн үед овоолгуудыг шүршиж чийгшүүлэх
	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал, утааны шүүлтүүр ашиглах, утааны хяналтын хэмжилтийг тогтмол хийлгэж байхаас гадна ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Жил бүр уулын ажил эхлэхийн өмнө нөлөөлөлд өртөх талбайн өнгөн (үржил шимт бараан) хөрсийг 0.5м зузаантайгаар хуулан авч "БО. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт" MNS 5916:2008 стандартын дагуу хадгалах шаардлагатай.
	Хөрс, ургамал, газрын хэвлийн элэгдэл, эвдрэлийг хамгийн бага байлгахын тулд зөвхөн нөөц тогтоогдсон хил хүрээнд олборлолтыг явуулж, жил бүр сөрөг нөлөөлөлд өртсөн, цаашид ашиглагдахгүй талбайг нөхөн сэргээдэг байх.
	Уурхайн дотоод болон гадаад тээвэрлэлтийн замыг засч сайжруулан тэмдэгжүүлж, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар зорчуулах, хурдыг хязгаарлах.
Усны нөөц, горимд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Шатах, тослох материал асгарч хөрсөнд нэвчин, хөрс, ус бохирдуулахаас сэргийлэн шатах тослох материал түгээх цэг болон засварын газар, автомашины зогсоолын суурийг цементлэх, асгарсан тохиолдолд тухай бүр нь саармагжуулах
	Ахуйн хог хаягдлыг үер, хур борооны усанд автахаргүй битүүмжилсэн хог хаягдал түр хадгалах талбайд цуглуулж, менежментийн төлөвлөгөөний дагуу устгах
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж эвдрэх талбайн өнгөн хөрсийг 0.5м зузаантайгаар хуулан стандартын дагуу хадгалах.
	Уурхайн олборлолтын үйл ажиллагаа дууссаны дараа төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртсөн бүх талбайг бүрэн нөхөн сэргээхээс гадна дахин ашиглагдахгүй нөлөөлөлд өртсөн талбайг тухай бүр нь нөхөн сэргээж байх.
Эрсдэл, аюулгүй ажиллагааны чиглэлээр	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтанд хамруулж, хувцас хэрэглэлээр бүрэн хангаж, өмсөж хэвшүүлэх
	Болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэл (Safety Data Sheet)-д заасан дараах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ашиглах дадлыг эзэмшүүлэх
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны алба, сумын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, санал солилцох, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх
	Ажлын шаардлагаар ухсан нүх, цооногт хүн, мал, зэрлэг ан амьтан орохоос сэргийлсэн хамгаалалтын түр хашаатай байлгах, ашиглалтын дараа ухсан нүх цооногийг газрын байдалд тохируулан тэгшлэх.
	Төсөл хэрэгжиж буй газрын ойролцоо ан амьтан агнахгүй байх, амьтан хамгаалах мэдээлэл, сурталчилгаа хийх, анхааруулсан зурагт хуудас байрлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх

2.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах


Олон улсын “TNC Mongolia” байгууллагын боловсруулсан “MDT-Mitigation Design Tool”-ийн загварчлалыг өгөгдлийн сан болон “Экологийн бүс нутгийн үнэлгээ”-ний ажлын үр дүнд үндэслэн дараах хүчин зүйлүүдийг харгалзан тооцоолсноор төслийн зүгээс дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай талбайн хэмжээ нь нийт 1813га болж байна.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийн хэмжээ

Хүчин зүйлс	Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээ, га
Амьдрах орчны ангилал	101
Экосистемийн төрөл	101
Ландшафтын эрүүл байдал	101
Ландшафтын байршил	755
Төслийн үргэлжлэх хугацаа	755
Нийт дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбай = 1813га	

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын тайланд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай газрын хэмжээг 1813га-аар тооцож, хамгаалах нутгийг төслийн талбайгаас зүүн урд зүгт 8км зайд орших “Баянгол-2” нэртэй орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг(ОНТХГН)-аар сонгосон ч Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 141 дугаар саналын дагуу Ерөө сумын 3 дугаар багийн нутагт, тусай зөвшөөрлийн талбайгаас зүүн урагш 45км орчим зайд орших Их Өлөнтийн ам нэртэй 5га эвдрэлд орж орхигдсон газарт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлыг хийхээр төлөвлөв. Аймгийн БОАЖГ-ын саналыг хавсаргав.

5 “Хүстай төмрийн хүдрийн орд ашиглах” төсөл



Солбилцол:
 107° 22' 48.103" 49° 24' 40.533"
 107° 22' 55.468" 49° 24' 36.583"
 107° 22' 49.329" 49° 24' 30.400"
 107° 22' 39.958" 49° 24' 33.686"

Зураг 4. Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон газар нутгийн байршил



ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний зорилго, зорилт

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино.

Гол зорилтууд: Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

БОМТ-нд нийт 70 ажил тус тус багтсан бөгөөд төслийн 2024 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 28.69сая.төг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 5. БОМТ-ний бүрэлдэхүүн хэсгүүд

№	Менежментийн төлөвлөгөө	Ажил	2023 оны зардал, сая.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	29	20.4
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	0	-
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	9	1.8
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	8	0.75
5	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6	0.29
6	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	11	1.25
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	4	-
8	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1	2.7
9	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	2	1.5
Нийт зардал		70	28.69



3.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

7
"Хустай төмрийн хүдрийн орд ашиглах" төсөл

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин				
1	Уурхайн дотоод тээврийн зам, овоолго зэргийг хуурайшилттай үед чийглэж байх	Осол эрсдлээс сэргийлэх	Уурхайн дотоод зардлаар	"Агаарын тухай", "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль,
2	Уурхайн хүнд механизмууд, тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийг стандартын түвшинд байлгах, агаарын бохирдлын төлбөр төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг байнга хийж байх		Уурхайн үйл ажиллагааны зардал	MNS 4585:2016, "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4597:2013 "Автозамын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага"
4	Баяжуулах үйлдвэрт тоос баригч төхөөрөмж суурилуулах	Тоосжилтоос сэргийлэх	7.500.0	MNS 5885:2008, "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага"
5	Хүдэр бутлах болон асгах машины хэсгийг битүүмжлэх, унжуулдаг хаалт хийх, хүдэр дамжуулах шугамын битүүмжлэлийг сайжруулах зэрэг боломжит шийдлүүдийг хэрэгжүүлэх		Уурхайн үйл ажиллагааны зардлаар	MNS ISO 4227:2002, "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 4990:2015, "ХАБЭМ. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага"
Хөрс орчин				
6	Хурдны хязгаарыг 30км/цаг-аас хэтрүүлэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах	Хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах	200.0	MNS 5915:2008 "БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал"
7	Үржил шимт өнгөн хөрсийг хуулан авч тусгайлан овоолго байгуулж нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгалах		Уурхайн үйл ажиллагааны зардлаар	MNS 5916:2008 "БО. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт"
8	Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох		Уурхайн дотоод зардлаар	MNS 5917:2008 "Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага"
9	Тээврийн хэрэгслийн маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбарууд, ус, хөрс, ургамал, мод зэргийг хамгаалах сурталчилгааны мэдээллийг байнга хийх		200.0	MNS 5918:2008 "Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага"



8
“Хустай төмрийн хүдрийн орд ашиглах” төсөл

10	Баяжуулах үйлдвэрийн хаягдалын цэгийг байгуулахдаа хүчил үүсгэдэггүй, хүчилд тэсвэртэй, ус үл нэвчүүлэгч материалыг ашиглах	Хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах	Уурхайн үйл ажиллагааны зардлаар	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль: Зүйл 10-1, 2, 3; Зүйл 11; Зүйл 12-2
11	Бүх төрлийн шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар (шавар, элс) доторлож, хальж асгарахаас сэргийлэх, түвшинд байнгын хэмжилт хийж байх			MNS 5850:2019 “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Газрын гадарга				
12	Уурхайг хаалт, нөхөн сэргээлтийн үед нийт талбайг цэвэрлэж, цооног нүхийг бөглөх, дүүргэх, хог хаягдал, техникийн эд анги үлдээхгүй байх	Уурхайн дотоод зардлаар	Уурхайн дотоод зардлаар	“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7-р зүйл, MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”,
13	Уурхайн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх			MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” “Газрын тухай” хууль, 50.1.1., 1.2., 55.2., 3-5-р зүйл.
14	Уурхайн хана, гадаргууг урт хугацааны турш тогтвортой байхаар засч хэлбэржүүлэх, аюулгүй байдалд оруулах			“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, 25.2. “Газрын хэвлийн тухай” хууль, 41.1-4.
Усан орчин				
15	Унд-ахуйд ашиглаж буй худгийг хашиж хамгаалах Худгийн эх үүсвэрийг хамгаалах хашаа нь 5м урт, 4м өргөн, 1м өндөртэй төмөр хайс байна.	Усны хомсдуулахгүй, цэвэршүүлж ашиглах	260.0	“Усны тухай” хууль “Ус бохирдуулсаны төлбөрийн тухай” хууль Усны нөөцийг хамгаалах журам. БО болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал 143/А/352
16	Усны эх үүсвэрүүдийг тоолууржуулах		300.0	MNS 4047:1988, “Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам” MNS 4943:2015, “Усны чанар, хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага”
17	Боловсон ариун цэврийн байгууламжийг барилга бүрт шийдвэрлэж, бохир усыг соруулан зөвшөөрөгдсөн цэгт хаядаг байхаар төлөвлөх		Гэрээнд заасны дагуу	MNS 4288:1995, “Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил цэвэрлэгээний технологийн түвшинд тавих үндсэн шаардлага”
18	Ахуйн бохир усыг шууд хөрс болон усанд нэвчихээс сэргийлж “Бохир усыг халдваргүйжүүлэн цэвэршүүлэгч систем (Septic Sewage System)”-ийг суурилуулах		Уурхайн дотоод зардлаар	



19	Уурхайн усыг зайлуулах, дахин ашиглах асуудал, ус цэвэршүүлэлт зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.	Усыг хомсдуулахгүй, цэвэршүүлж ашиглах	Уурхайн үйл ажиллагааны зардлаар	MNS 4586:1998, "Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага" MNS 0900:2010, "ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ"
Ургамлан нөмрөг				
21	Ургамлын нөмрөг нь хуулагдах болон нөлөөлөлд өртөхгүй талбайнуудыг тодорхой болгох, зурагжуулах	Ургамлан нөмрөгийг хамгаалах	Уурхайн дотоод зардлаар	Байгалийн ургамлын тухай" хууль, 7-р зүйл. Ургамлыг хамгаалах.
22	Ховор, ховордож байгаа болон хожим нөхөн сэргээлтэд ашиглах орон нутгийн ургамлыг үр, ургал эрхтнээр ургуулан нүүлгэн шилжүүлэх		4.000.0	"Ургамал хамгааллын тухай" хууль: 3үйл 8-1, 2 MNS 5917:2008 "Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага"
23	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох		Уурхайн дотоод зардлаар	MNS 5918:2008 "Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага"
24	Ургамлын хяналт, судалгааны ажлыг холбогдох эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгэх		Гэрээт ажлын үнийн дүнгээр	
Амьтны аймаг				
25	Ан хийхийг хориглох	Ан амьтныг хамгаалах	Уурхайн дотоод зардлаар	"Амьтны аймгийн тухай" хууль, 6-р зүйл: 6.1.3, 6.1.4, 6.1.6, 6.1.7, 6.1.8. 25-р зүйл. "Ан агнуурын тухай" хууль
26	Шинээр зам байгуулахдаа ан амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байхаар тооцон нэг түвшний гарц гарам барьж байгуулах		Үйл ажиллагааны зардлаар	
27	Зэрлэг ан амьтдын менежментийн болон тоо толгойн хяналт, амьдрах орчны судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх		Уурхайн дотоод зардлаар	
28	"Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр"-ийг Сэлэнгэ аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэх		Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн зардлаар	
29	Мэргэжлийн байгууллагатай хамтран бүс нутгийн амьтны аймгийн урт хугацааны мониторинг явуулах		6.000.0	
Нийт зардал			20.460.0	

3.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2024 он нь ашиглалтын эхний жил болох тул энэ онд техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй, уурхайн бүрдэл хэсгүүдийн шимт хөрсийг хуулж хадгална.

Биологийн нөхөн сэргээлтийг ашиглалтын 5 дахь жилээс хийхээр төлөвлөсөн.



Хүснэгт 7. Хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэрэгжих хугацаа, зардал, сая.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг хуулж хадгалах	-	"Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай" хуулийн 7-р зүйл, MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт", MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт" "Газрын тухай" хууль, 50.1.1., 1.2., 55.2., 3-5-р зүйл. "Байгаль орчныг хамгаалах тухай" хууль, 25.2. "Газрын хэвлийн тухай" хууль, 41.1-4.
	Шимт хөрсийг тараах, шимт хөрсөөр хучих ажил		
Биологийн нөхөн сэргээлт	Ургамалжуулах ажил	-	
	Орчны тоосжилт болон салхины хурд бууруулах, зорилгоор мод бут тарих, орчныг ургамалжуулах, овоолгын гадаргуу, хажууг хэлбэршүүлэх, олон наст ургамал тарих		
	Хөрс сайжруулалт ба усалгааны ажил		
Нийт зардал		-	

3.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд аймгийн БОАЖГ-ын саналын дагуу Их Өлөнтийн ам нэртэй 5га талбайд "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ыг баримтлан ойжуулалт хийх ба аргачлалын дагуу талбайд 1800 ширхэг орчим улиас модны 1 настай суулгац тарихаар төлөвлөв.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжих хугацаа, давтамж	Зардал, сая.төг
Ойжуулалт хийх	Дүйцүүлэн хамгаалал хийхээр сонгогдсон талбай	2023 онд	1800ш x 1500**төг=2.7
Нийт зардал			2.7

**2023 оны 04 дүгээр сарын Улиас модны 1 настай суулгацын ханш тул цаг үеэс хамааран өөрчлөгдөж болно.

3.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Буургачин багийн иргэд	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох шаардлагын талаарх судалгаа хийх, ажлын төлөвлөгөө, журам боловсруулах	Төслийн эхэн үе шатанд	Дотоод зардлаар	2023 онд	Ашигт малтмалын тухай хуулийн 41-р зүйл
	Нөхөн төлөх төлбөрт шаардагдах зардлыг төлөх				
Нийт зардал			1.5	-	-



3.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, осол, аюулын үед авч хэрэгжүүлэх үүднээс төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагааны хүрээнд эрсдлийн менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллаж, тохиолдож болзошгүй эрсдлийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний зардалд зориулан “Эрсдлийн сан” үүсгэх ба байнгын бэлэн байлгах шаардлагатай.

Хүснэгт 10. Эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ, Нэгжийн зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн барим бичиг	
Осол эрсдэл							
1		Эрсдлийн сан бий болгох		1.500.0			
2	Галын аюул, хэрийн түймэр	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулж байнгын бэлэн байлгах	Үйлдвэрийн хүрээнд	-	Төслийн хугацаанд	“Гамшгаас хамгаалах тухай” хууль: 27.1 “Галын аюулгүй байдлын тухай” хууль: 16-1, 2; 18-1, 2; 19 1, 2; 20-1, 2; 21-1, 2, 3; БНБД 21-01-02 Барилгын гал тэсвэршилтийн зэрэг	
3		Аюулын гарц заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах		300.0			
4		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах		Гэрээнд заасны дагуу			Улирал бүр
5		Хяналтаас гадуурх тэсэлгээний ажил		Тэсэлгээний ажлыг нарийн төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэдэг байх			Үйл ажиллагааны зардлаар
6	Тэсэлгээний үед ажилчдыг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангах		Шаардлагатай үед				
7	Хүчтэй салхи, шуурга, аянга цахилгааны осол	Хүчтэй салхи, шуурганы үед үзэгдэх орчин хязгаарлагдсан үед уурхайн тээвэрлэлт, тэсэлгээ зэрэг ажлыг түр хугацаанд зогсоох	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн хугацаанд	Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13688:2000		
8	Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байршуулах					Төслийн хугацаанд	
9	Тоног төхөөрөжлийн аюулгүй ажиллагаа	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах				Өдөр бүр	
10	Машин техникийн осол	Жолооч бүрийг даатгалд хамруулах		Жилд 1 удаа			
11		Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулах			Төслийн хугацаанд		
Нийт зардал					1.800.0		



3.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	400.0	"Хог хаягдлын тухай хууль"-ийн 10.2.1-р зүйл
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушааж байх, хог хаягдлыг дахин ашиглах зэрэг хог хаягдлын хэмжээг багасгах арга хэмжээг авах	Үйлдвэрийн эзэмшил газрын хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаар	"Эрүүл ахуйн тухай хууль"-ийн 4.4.3, "Хог хаягдлын тухай хууль"-ийн 9.2.8, 9.2.9, 12-р зүйл
Сар бүр хог хаягдлаа тээвэрлэж зайлуулах		Гэрээнд заасан дүнгээр	"Хог хаягдлын тухай хууль"-ийн 10.2.3-р зүйл
Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах		350.0	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	Үйл ажиллагааны зардлаар		
Бохирын цооногт 1м ³ бохирт 1л био бэлдмэл байхаар тооцож тогтмол ариутгал хийх	Хог хаягдлын цэг	Гэрээнд заасан дүнгээр	Эрүүл ахуйн тухай хууль
Дахин боловсруулах хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах			"Хог хаягдлын тухай хууль"-ийн 10.2.8-р зүйл
Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан УБ хотод НВОil хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах	Үйлдвэрийн эзэмшил газрын хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаар	-
Нийт дүн		750.0	



3.8. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцоо, сая. төг	Хэрэгжих хуваарь Хугацаа:	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод зардал	Төслийн хугацаанд	Компанийн удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31 дүгээр зүйл
2	Экологийн паспорт хөтлөх			БО-ны мэргэжилтэн	-
3	Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх	Гэрээнд заасны дагуу	2 жил тутамд	Менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 10 ¹ дэх зүйл
4	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	Үйл ажиллагааны зардал	Улирал бүр		"Хог хаягдлын тухай хууль"-ийн 10.2.16-р зүйл
5	Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдлийн талаар сургалт зохион байгуулах	Гэрээнд заасны дагуу	Сар бүр	ХАБЭА-н ажилтан	-
6	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Дотоод зардал	Төслийн хугацаанд	Менежер	"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 14.1.2-р заалт
7	Тусгай зөвшөөрөлтэй талбайд Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гэрээнд заасны дагуу	5 жил тутамд		"Газрын тухай хууль"-ийн 58-р зүйл
8	Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх	Үйл ажиллагааны зардал	Төслийн хугацаанд		"Хог хаягдлын тухай" хуулийн шинэчилсэн найруулга, 2017
9	Үйлдвэрийн байрыг үйлдвэрлэлийн нөхцөлд нийцүүлэх барьж байгуулах				-
10	Уурхайг тойруулан үерийн усны хамгаалалтын суваг болон далан байгуулах			-	
11	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 500ширхэг мод тарих	1.25*	2023 онд	БО-ны мэргэжилтэн	У у р х а й н тосгоныг ногоон байгууламжуулах
Нийт		1.25	-	-	-

*2024 оны уулын ажлын төлөвлөгөөг үндэслэв.

**3.9. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн орчны агаар, ус, хөрснөөс жил бүр тогтоосон цэгээс сорьц авч, шинжлүүлэх, үр дүнг холбогдох байгууллагуудад тайлагнах үүрэгтэй.

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд, ЗДХ	Хяналтын цэгийн байршил	Давтамж	Нэгж үнэ мян.төг	Баримтлах стандарт, арга, оргачлал
Агаар				
Нүүрстөрөгчийн дутуу исэл, CO	Дотор агаар: Баяжуулах үйлдвэр Гадны агаар: Ил уурхай, овоолгын доор болон хаягдлын сан (зонхилох салхины чиглэлийн дагуу)	Жилд 2 удаа	2*50.0	"Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016
Хүхрийн давхар исэл, SO ₂				
Азотын ислүүд, NO _x				
Нийт тоос, TSP				
Том ширхэгт тоос, PM10				
Нарийн ширхэгт, PM2.5				
Гэрэлтүүлэг				
Ажлын байрны дуу чимээ				
Дуу чимээ- 80ДБА	Уурхайн гадна талбайгаас	Жилд 2 удаа	2*25.0	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000
Хөрс				
Хром, Cr	Авто зогсоол/ Засварын газар, Хүдрийн овоолго, Хоосон чулуулгийн овоолго Хогийн цэг, Бохирын цооногийн дэргэдээс	Жилд 2 удаа	2*50.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019
Хар тугалга, Pb				
Кадмий, Cd				
Никель, Ni				
Цайр, Zn				
Зэс, Cu				
Төмөр, Fe				
Ундны ус				
pH	Худгийн ус	Жилд 2 удаа	2*22.0	"Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018
Ерөнхий хатуулаг				
Хлорид ион				
Сульфатын ион				
Кальцийн ион				
Магнийн ион				
Натри ион				
Ургамлан нөмрөг				
Зүйлийн тоо	Уурхайн бүс, Ажилчдын тосгон, Овоолго, Хяналтын талбай, Нөхөн сэргээлт хийсэн талбай	Жилд 1 удаа VII/20-Х/20	Гэрээнд заасан дүнгээр	Төлөв байдлын үнэлгээний хэсэг дэхь ургамлын бүрхэвчийн судалгаатай харьцуулан үзэх
Бүрхэц				
Ургамлын дундаж өндөр				
Биомасс				
Амьтны аймаг				
Зүйлийн бүрдэл	Уурхайн бүс, дэд бүтцийн шугам дагуу, автозам дагуу	Сард 1 удаа	Гэрээнд заасан дүнгээр	Төлөв байдлын үнэлгээний хэсэг дэхь амьтны аймгийн судалгаатай харьцуулан үзэх
Тоо толгой, байршил, тархац				
Нүүдэллэн өнгөрөх хугацаа				
Нийт зардал			294.0	

3.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-г боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

15
"Хустай төмрийн хүдрийн орд ашиглах" төсөл

Оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Агуулга	Хугацаа	Санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Иргэд, багийн ИНХ	Тайлагнах, хэлэлцүүлэх	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн 10 сард	Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулах	Компанийн байранд
Шаардлагатай тохиолдолд сонирхогчид, байгаль орчны төрийн бус байгууллага			Шаардлагатай тохиолдолд		
Аймгийн байгаль орчны газар	Тайлагнах	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан	Жил бүрийн 11 сарын 1-ний дотор	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	Аймгийн байгаль орчны газарт
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12-р сарын 31-ны дотор	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



ХАВСРАЛТ

1. Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хуулбар
2. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл, хавсралтын хуулбар
4. Аймгийн БОАЖГазрын 2022.04.18-ны өдрийн саналын хуулбар
5. Сумын засаг дарга, аймгийн Байгаль орчны газар, Үйл ажиллагаа явуулаагүй тухай албан бичгийн хуулбар
6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний батлагдсан нүүрний хуулбар
7. Дэвсгэр зургийн хуулбар
8. Иргэдийн нийтийн хурлын тогтоол, тэмдэглэлийн хуулбар
9. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон 2021-2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсан нүүрний хуулбар
10. Эрдэс баялаг, эрчим хүчний яам. Ашигт малтмалын газар. Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2012.02.16-ны өдрийн ХХ-04-02 дугаар дүгнэлтийн хуулбар
11. Монгол орны тусгай хамгаалалттай газар нутаг болон гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхцалгүй тухай лавлагааны хуулбар
12. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмалын газар. Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай дүгнэлтийн хуулбар, 2021.02.10
13. Сумын Засаг дарга, Ус ашиглах гэрээний хуулбар
14. Усны газар, Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн хуулбар
15. "Нарт Шүүн Консалтинг" ХХК-ийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторийн хөрсний шинжилгээний дүнгийн хуулбар
16. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан уулын оргил” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн Чөлөө
“Бизнес плаза” 501 тоот

Утас: 7013 1114, 9918 4930

И-мэйл: tsagaanuuiliinorgil@gmail.com

Фэйсбүүк: “Цагаан уулын оргил” ХХК Байгаль орчны зөвлөх үйлчилгээ